# ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2018 оны 04 сарын 17 өдөр Дугаар 134 Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Зам, тээврийн хөгжлийн яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, ашиглалтын шаардлага хангахгүй болсон нийт 109,149,476.00 (нэг зуун есөн сая нэг зуун дөчин есөн мянга дөрвөн зуун далан зургаан) төгрөгийн балансын үнэ,80,168,066.90 (наян сая нэг зуун жаран найман мянга жаран зургаан төгрөг ерэн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Бат-Эрдэнэд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, сэлбэгээр худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА Ц.НЯМ-ОСОР

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Э.ЭРДЭНЭХИШИГ

Боловсруулсан: ...
Хянасан: ...
Хуул...

0001765

D:\Huraldaanii material\2018 on\2018.04.17\07docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 04 дүгээр сарын 14-ны өдрийн 131 дугаар тогтоолын хавсралт

**Зам, тээврийн хөгжлийн яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй акталж, данснаас хасах хөрөнгийн жагсаалт**

| д/д | Хөрөнгийн нэр | Хэмжих нэгж | Ашиглалтад орсон он | Тоо хэмжээ | Нэг бүрийн үнэ (төгрөгөөр) | Балансын дүн (төгрөгөөр) | Хуримтлагдсан элэгдэл (төгрөгөөр) | Үлдэгдэл өртөг (төгрөгөөр) |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Цанын баазын Төлбөр хураах цэгийн байр | ш | 2006 | 1 | 55,733,473.00 | 55,733,473.00 | 26,752,066.90 | 28,981,406.10 |
| 2 | Сансарын холбооны редиум гар утас | ш | 2005 | 1 | 13,176,000.00 | 13,176,000.00 | 13,176,000.00 | 0.00 |
| 3 | Холбооны станц | ш | 2004 | 1 | 40,240,000.00 | 40,240,000.00 | 40,240,000.00 | 0.00 |
| | | | | 3 | | 109,149,473.00 | 80,168,066.90 | 28,981,406.10 |
| | **Нийт хөрөнгийн дүн** | | | **3 (гурав)** | | **109,149,476.00 (нэг зуун есөн сая нэг зуун дөчин есөн мянга дөрвөн зуун далан зургаан)** | **80,168,066.90 (наян сая нэг зуун жаран найман мянга жаран зургаан төгрөг ерэн мөнгө)** | **28,981,406.10 (хорин найман сая есөн зуун наян нэгэн мянга дөрвөн зуун зургаан төгрөг** |